



# “ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 1/12

Улаанбаатар хот

## Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот гогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ын 2.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 3.3, 3.20.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Женко тур бюро” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Женко тур бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтаар Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг, Хоёрдугаар хавсралтаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг, Гуравдугаар хавсралтаар Саналын хуудасны агуулга, загварыг, Дөрөвдүгээр хавсралтаар Хурлын нийтэд хүргэх зарын загварыг, Тавдугаар хавсралтаар Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалт-ыг тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор нийтэд зарласугай, Давтан зарыг 2025 оны 04 дүгээр сарын 08-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлийн өдрийг хурал хуралдах өдрийн өмнөх өдөр буюу 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:00 цагаар тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Ц.Түмэнхишиг, хуралдаан зохион байгуулах комиссын даргаар Т.Гэрэлчимэг (ТУЗ-ын нарийн бичгийн дарга), гишүүнээр Ч.Ариунзаяа (Хүний нөөцийн менежер), Оюунтуяа (нягтлан бодогч) нарыг, тооллогын комиссын даргаар Ч.Гэрэл (Ахлах нягтлан бодогч), гишүүнээр С.Ичинхорлоо (Аяллын албаны дарга) нарыг тус тус томилсугай.
8. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зар мэдээг хүргэх, холбогдох мэдээллийг бэлтгэх зэргээр энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Намуун/-д даалгасугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг гүйцэтгэх захирал /Б.Намуун/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮМЭНХИШИГ